



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 11 дугаар сарын 21

№ 01/83

Мандалговь хот

**Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 заасан бүрэн эрхийн хүрээ, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9 дэх заалт, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэрэн сумын Цэцэрлэгийн 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийх явцад батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй нийт 12,300,877.00 /арван хоёр сая гурван зуун мянга найман зуун далан долоо/ төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 04 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хэрэгцээг илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэм”-ийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-т /Хууль тогтоомж зорчсон алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нормативт зардлыг хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дэрэн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Р.Нэргүй, нягтлан бодогч П.Оюунчимэг нарт хариуцуулав.

**ӨГСӨН:**  
АУДИТОР *Б.ГАНТУЯА* Б.ГАНТУЯА  
4817144213  
ЗЮА0039 9030475

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЭРХЛЭГЧ *Р.НЭРГҮЙ* Р.НЭРГҮЙ  
НЯГТЛАН БОДОГЧ *П.ОЮУНЧИМЭГ* П.ОЮУНЧИМЭГ

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэнэ/